МЭДЭЭ · 2022 оны 11-р сарын 23

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ЗААСАН ХУГАЦААНД БҮРЭН, БОДИТОЙ ЭДЛҮҮЛЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд гэнэтийн болон төлөвлөгөөт байдлаар шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, тодорхой үр дүнд хүрээд байна.

Тодруулбал, ажил олгогч байгууллагууд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн иргэдийн ажлын цагийг зохих журмын дагуу бүртгэдэггүй нийтлэг зөрчил байсныг дахин гаргахгүй байх зорилгоор Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран цахим бүртгэлийн системийг нэвтрүүлж эхэлжээ.

Энэхүү бүртгэлийн системийг нэвтрүүлснээр дүүргийн хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 200 гаруй иргэний ялыг шүүхийн шийдвэрт заасан хугацаанд бүрэн, бодитой эдлүүлэх боломж бүрдсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2027